

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

**2020 оны ... дугаар  
сарын ... - ны өдөр**

**Улаанбаатар  
хот**

**Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт  
өөрчлөлт оруулах хуулийн төсөл**

**1 дүгээр зүйл.** Ашигт малтмалын тухай хуулийн дор дурдсан өгүүлбэрийг хассугай;

4 дүгээр зүйлийн 4.1.23 дэх хэсгийг "... үйлдвэрлэлийн аргаар ашиглахад эдийн засгийн үр ашиггүй орд, ...", "...Иргэний хуулийн 481-д заасны дагуу бүртгэгдээгүй нөхөрлөлийн, ..." гэсэн өгүүлбэрийг тус тус хассугай.

**2 дугаар зүйл.** Ашигт малтмалын тухай хуулийн дор дурдсан хэсгийг хүчингүй болсонд тооцугай;

11 дугаар зүйлийн "11.1.23 дэх хэсгийг", мөн хуулийн 12 дугаар зүйлийн "12.1.5 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцугай;;

**3 дугаар зүйл.** Ашигт малтмалын тухай хуульд дор дурдсан нэмэлт оруулсугай;

3/11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсэг

"11.4.Ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл олгохдоо байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас санал авна." гэж нэмэх

**Гарын үсэг**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

**2020 оны ... дугаар  
сарын ... - ны өдөр**

**Улаанбаатар  
хот**

**Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт  
оруулах хуулийн төсөл**

**1 дүгээр зүйл.** Газрын тухай хуулийн дор дурдсан заалт, хэсгийг хүчингүй болсонд тооцсугай;

“16 зүйлийн 16.1.11 дэх хэсгийг ” , мөн хуулийн 16 зүйлийн 16.2 дах заалтын “...16.1.11...” дэх гэснийг тус тус хүчингүй болсонд тооцсугай;

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай батлагдсан өдрөөс дагаж мөрдөнө.

**Гарын үсэг**